

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-31

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 6-31

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
10 дугаар сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 48 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Цэнгүүн, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ч.Анар, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, А.Ундраа;

Тасалсан: Н.Батсүмбэрэл, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Ч.Лодойсамбуу, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Н.Ууганбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, мөн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Тамгын газрын дарга Б.Лхагва, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга С.Цогтгэрэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, мөн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, Санхүүгийн хэлтсийн дарга Т.Сумъяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга

Д.Энхбаатар, Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын дарга М.Ням-Очир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Уянга, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, мөн яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, мөн газрын ахлах шинжээч М.Одбаяр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга А.Амгаланзаяа, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч В.Батчимэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Амартүвшин, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах газрын дарга Д.Батбаяр, мөн яамны Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батзаяат, Сүлжээний дэд бүтцийн хэлтсийн дарга Ч.Гүнсэнхорол, Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Дэлгэрмаа, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, мөн албаны референт Х.Сүхбаатар, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Баянмөнх, Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбаяр, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батхуяг, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгт, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, “Үндэсний дата төв” УТҮГ-ын захирал М.Баттулга, “И-Монгол Академи” УТҮГ-ын захирал Б.Мягмарнаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Х.Шижирмөнх нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулав.

Хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ш.Бямбасүрэн, Б.Уянга, О.Батнайрамдал, М.Мандхай, П.Ганзориг, М.Бадамсүрэн, С.Эрдэнэбат, Ц.Баатархүү, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900239 төслийн кодтой “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд аймгийн Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 9 тэрбум 438 сая 300 мянган төгрөг, 2026 онд санхүүжих дүн 2 тэрбум 831,5 төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 12
Бүгд: 18
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900237 төслийн кодтой “Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, аймгийн Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3 тэрбум 953,6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 1 тэрбум 779,2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 13
Бүгд: 18
27.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, аймгийн Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8 тэрбум 396,8 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 3 тэрбум 778,6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн

авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202 тэрбум 137,9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23 тэрбум 950,1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 641,6 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Шихихутаг нууц товчоо түүхэн аялал жуулчлалын цогцолбор барилга”-ын нэмэлт төсөв /Хэнтий аймаг, Норовлин сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 онд, төсөвт өртөг, санхүүжих дүн 641,6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэл хатуу хучилттай авто зам, 152,5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202 тэрбум 137,9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 24 тэрбум 950,1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 238,6 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Их хуралдай цогцолборын барилгын гадна тохижилтын нэмэлт ажил, хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 238,6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5 км, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202 тэрбум 137,9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23 тэрбум 950,1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 685 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Монголын нууц товчоо цогцолборын барилга”-ын гадна тохижилтын нэмэлт ажил, /Хэнтий, Дэлгэрхаан сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 685 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700119 төслийн кодтой, “Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюун ухаан, их өгөгдлийн суурь дэд бүтцийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 19 тэрбум 445 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын төсвийн багцад “Өсвөрийн инженерүүдийн инновацийн төвийн барилгын ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих

хугацаа 2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40 тэрбум төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад “Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүүтерийн гүүрэн тусгай зам барих ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 46 минут үргэлжилж, 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 48 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Ринчиндоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Шинэбаярын Бямбасүрэн, Пүрэвжавын Ганзориг, Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Бадрахын Найдалаа, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Болдын Уянга, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд оролцож байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53,1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл, Засгийн 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж, 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Ирэх 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа.

Төсвийн төсөлд туссан тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах онцлох арга хэмжээнүүдийг дурдъя. 1 дүгээрт, төсвийн урсгал зардлын хувьд удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын нийт орон тооны тэлэлтийг хязгаарлахын зэрэгцээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн байгууллагын үр ашиггүй зардлыг бууруулж, хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулахаар, Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 17 дугаар бага хурлыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах болсонтой холбогдуулж хурлын бэлтгэл ажлыг хангах, улс орноо сурталчлан таниулах, мэдээлэл түгээх, дамжуулах, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах, олон улсын зочид, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, тав тухтай орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг санхүүжүүлэхээр, геологийн салбарыг уул уурхайн салбараас түрүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орчныг бүрдүүлэх, геологи, эрдэс баялгийн судалгааны ажлыг дэвшилтэт техник, технологиор гүйцэтгэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг 2025 онтой харьцуулахад 30 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр,

Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилгоор 2023-аас 2028 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулж тус салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор хөнгөлөлттэй зээл олгохоор Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоолоор шийдвэрлэлээ. Тогтоолын хүрээнд 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн 10 хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулж 6 хувийн хүүтэй, 6 хүртэлх жилийн хугацаатай нийт 267 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2026 онд олгохоор тооцоолж, зээлийн хүүгийн дэмжлэгт зориулж 23,1 тэрбум төгрөгийг төрөөс хариуцан төлөхөөр,

Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээгээ Монголын хөрсөнд ургасан эрүүл хүнсээр бүрэн хангахаар тусгагдсан. Энэ хүрээнд эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс болох зорилтыг дэвшүүлж, Хүнсний хангамж, аюулгүй байдал, Шинэ хоршоо-чинээлэг малчин, Цагаан алт, Атрын 4 дүгээр үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээлийг олгож, төрөөс зээлийн хүүгийн дэмжлэг олгохоор,

Цахим шилжилтийн дунд хугацааны төлөвлөлтийн хүрээнд төрийн их өгөгдөлд суурилан зөвшөөрөл олгох үйл явцыг хялбаршуулах, төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх, салбар дундын цахим шилжилтийг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг тус тус төсвийн төсөлд тусгасан болно.

2 дугаарт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэл, салбарын яамны түвшинд үе шаттайгаар төлөвлөсөн. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14,4 их наяд төгрөгийн санхүүжих дүн бүхий 1712 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж, 579 төсөл, арга хэмжээнд 3 их наяд 267,3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд

тусгасан болно. Нийт хөрөнгө оруулалтын 67 хувь буюу 2 их наяд 181,9 тэрбум төгрөг нь үргэлжлэн хэрэгжих бол, 33 хувь буюу 1 их наяд 85,5 тэрбум төгрөг нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна. Энэ нь 2022-оос 2023 онд батлагдсан төслийн тоотой харьцуулахад 2 дахин буурсан үзүүлэлт бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илтгэж байна.

Түүнчлэн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтад хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарт бүсчилсэн хөгжил болон хувийн хэвшлийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд эрчим хүч, суурь дэд бүтцийн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын салбарт, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үүднээс батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг түлхүү төлөвлөлөө.

Тухайлбал тус Байнгын хороонд хамаарах салбар буюу Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад 112,9 тэрбум төгрөг, Сангийн сайдын багцад 151,7 тэрбум төгрөг, Зам, тээврийн сайдын багцад 902,8 тэрбум төгрөг, Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад 169,4 тэрбум төгрөг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад 220,7 тэрбум төгрөг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад 26,3 тэрбум төгрөг, Эрчим хүчний сайдын багцад 322,4 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Мөн олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын КОП17 хурлыг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилт, гадаад зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгийг төсөвт мөн тусгалаа.

3 дугаарт, Засгийн газрын өрийн хувьд. Улсын Их Хурлаас 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан Засгийн газрын өрийн удирдлагын 2026-аас 2028 оны стратегийн баримт бичгийн зорилт, арга хэмжээг мөрдөн ажиллах бөгөөд 2026 онд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх, 1 тэрбум ам.доллар хүртэлх Засгийн газрын өрийн баталгаа гаргах, аймаг, нийслэлийн үнэт цаасыг зохистой хэмжээнд арилжаалах, дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжиж, суурь хүүг тогтоох зорилгоор 562, 62 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас гаргах, дахин санхүүжүүлэх зорилгоор 1 тэрбум ам.доллар хүртэл гадаадын үнэт цаас арилжаалахаар төсвийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн 2026 онд Засгийн газрын өрийн үйлчилгээнд 3,9 их наяд төгрөг төлөхөөр байгаагаас үндсэн төлбөрт 2,6 их наяд төгрөг, хүүгийн төлбөрт 1,3 их наяд төгрөгийг төлөхөөр байна. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 2025 онд 44,5 хувь, 2026 онд 43,7 хувьтай тэнцэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлага болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд туссан хязгаарыг хангаж байна.

4 дүгээрт, Үндэсний баялгийн сангийн хувьд. Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын 4.6-д заасан зорилтыг хангах хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталж, хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш нэг жил гаруй хугацаа өнгөрөөд байна. Газрын

хэвлий дэх байгалийн баялгийг ирээдүй хойч үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс ирээдүй өв санд хуримтлал бүрдүүлж ирсэн бөгөөд түүхэндээ анх удаа хөрөнгө оруулалтын өгөөжөөр тус сангийн хөрөнгийг арвижуулаад байна.

Тухайлбал Ирээдүй өв санд нийт 1 тэрбум 323,3 сая ам.долларын хөрөнгө төвлөрч, уг хөрөнгийг гадаад улсын төв банкнуудад байршуулснаар өнөөдрийн байдлаар 26,8 сая ам.доллар буюу 96,3 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг санд төвлөрүүлээ. Түүнчлэн хууль хэрэгжсэнээс хойших хугацаанд Хуримтлалын сангийн дансанд 754,4 тэрбум төгрөг төвлөрч, иргэн бүхэн ИМонгол системээр дамжуулан өөрийн хуримтлалыг бүрдүүлж байгаа эх үүсвэрийн хамт харах тогтолцоо бүрдээд байна. Ингэснээр Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хуримтлал 5 их наяд 509,5 тэрбум төгрөгт хүрээд байгаа бол ирэх онд ашигт малтмалын нөөц ашигласны орлогоос 2 их наяд 186,9 тэрбум төгрөгийг Ирээдүй өв санд, уул уурхайн салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн 34 хүртэлх хувьд ноогдох ноогдол ашгаас 372,9 тэрбум төгрөгийн орлогыг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн төсөлд тусгалаа.

Мөн ирэх онд тус сангуудын хөрөнгийг өсгөж, арвижуулах бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ингэснээр Ирээдүй өв сангийн хөрөнгийг 240,3 тэрбум төгрөг, Хуримтлалын сангийн хөрөнгийг 156 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хүүгийн орлогоор тус тус өсгөж арвижуулахаар хуулийн төсөлд тусгасан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31,6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 29,6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь байж, төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангахаар байна. Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Ажлын хэсгийг танилцуулъя. Хугацаа хэмнэх үүднээс ажлын хэсгийг төлөөлж ирсэн байгууллагыг, байгууллагын төлөөллийг танилцуулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Үндэсний аудитын газраас Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч, Эдийн засгийн хөгжлийн яам Батхүү Төрийн нарийн бичгийн дарга, ингээд ард нь дандаа нөгөө дагалдан яваа ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй гэсэн үг. Шадар сайдын ажлын алба Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын хэсгийн албаны дарга, Сангийн яам Ганбат Төрийн нарийн бичгийн дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн Уул уурхайн бодлогын газрын дарга, Зам, тээврийн яам Насантогтох Төрийн нарийн бичгийн дарга, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Даваацэрэн Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр

орлон гүйцэтгэгч, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Баяраа Төрийн нарийн бичгийн дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Тулга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Д.Батбаяр Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч, Эрчим хүчний яам Хуягцогт Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Санхүүгийн зохицуулах хороо Цогтгэрэл Ажлын албаны дарга, Үндэсний статистикийн хороо Батдаваа хорооны дарга гэсэн ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Бямбасүрэн гишүүнээр тасалъя. Ирцийн дарааллаар Улсын Их Хурлын гишүүн, Баатархүү гишүүнийг нэмье. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд асуулт асууна.

Л.Соронзонболд: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд орж ирж байгаа юун дотор энэ Эдийн засгийн хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд, Үндэсний статистикийн хорооноос энэ судалгаа хөгжүүлэлтийн зардал дээр бусад яам, агентлагийг бодвол харьцангуй их мөнгө тавигдсан байна л даа. Тэгэхээр энэ 3 яамнаас ҮСХ-ноос энэ судалгаа хөгжүүлэлтийн зардлаар яг ямар ажлууд хийх гэж байгаа вэ гэдэг талаар тодруулж асууя?

Р.Сэддорж: Батдаваа дарга 5 номер луу очоод суучих уу? 5 номер.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Соронзонболд гишүүний асуултад хариулъя. ҮСХ-ны бусдаар гүйцэлдүүлэх ажил үйлчилгээ дээр Статистикийн тухай хуульд заасан ҮСХ-ноос явуулдаг тухайн жилд явуулах ёстой тооллого, түүвэр, судалгааны зардлыг үйл ажиллагааны ангиллын дагуу оруулсан байдаг. Энэ хүрээнд ирэх жилд манайд гол хийгдэх ажлууд гэвэл Статистикийн тухай хуульд заасан аж ахуйн нэгж, байгууллагын 5 жил тутам явуулах тооллого, жил болгон явуулах ёстой өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаа, ардчилсан засаглалт судалгаа, мал, тэжээвэр амьтны жилийн болон хагас жилийн тооллого гэх мэт судалгаанууд багтсан байгаа.

Р.Сэддорж: Эдийн засгийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам дараа нь. 1 номер, Учрал сайд хариулъя. Учрал сайдын микрофон.

Н.Учрал: Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулиар Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудалд шинжлэх ухааны салбар багтсан. Тэгэхээр Шинжлэх ухааны академи, хүрээлэнгүүдийн зардал л Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад хамаардаг. Мөн Шинжлэх ухаан, технологийн сан гэж нөгөө хэрэглээний судалгаануудыг дэмждэг сан байдаг, Засгийн газрын тусгай сан бие даасан хуультай. Энэ Шинжлэх ухаан, технологийн сангийн зардал нөгөө судалгааны зардал шиг харагдаж байгаа байх. Гэхдээ Шинжлэх ухаан, технологийн сангийн зардал өмнө жилээс 2 дахин буурсан байгаа юм. Тэгэхээр энэ зардал бол Шинжлэх ухааны академи, хүрээлэнгүүд, нөгөө Шинжлэх ухааны технологийн сан дээрх зардал болохоос биш Эдийн засаг, хөгжлийн яам судалгаа, хөгжүүлэлтийн зардал гэж тусгайлан байхгүй.

Р.Сэддорж: 1 номер.

О.Хуягцогт: Эрчим хүчний яамнаас Соронзонболд гишүүний асуултад хариулъя, Хуягцогт. Эрчим хүчний яамны урсгал зардал дээр бараа, үйлчилгээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал гэж ангилалд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэхэд Монголын талаас хүлээсэн үүргийн дагуу түүх, соёлын өв, дурсгалт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, хамгаалах, нөлөөлөлд өртөж байгаа айлуудын нөхөн олговрыг олгох энэ зардал, мөн Эгийн голын усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэхэд ЮНЕСКО болон Оросын Холбооны Улсын ШУА-удын хоорондын хамтарсан гэрээ хэлэлцээрийн дагуу Дэлхийн өвийн хорооны аргачлал олон улсын стандартад нийцүүлж хийх, байгаль, орчин нийгмийн үнэлгээ хийх энэ зардлууд тусаж байгаа юм. Тэгээд саяын энэ жилийн төсөв дээр нөгөө зардлын ангиллыг илүү нарийвчлаад эдгээр зардлууд саяын дурдсан ангилалд бүртгэгдсэн байгаа. Өмнөх жилүүдэд тусаж байсан ийм төслийн онцлогтой зардлууд байгаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн.

Ш.Бямбасүрэн: Байнгын хороон дарга, эрхэм гишүүд, ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Улсын төсвөөс хувийн хэвшилд олгож байгаа татаас жил болгон нэмэгдэж байгаа. Тэгээд энэ жилийн хувьд ер нь аль, аль салбарт ер нь энэ татаасууд олгогдож байгаа вэ? Энэ татаас өгч байгаа байгууллагуудыг ер нь хэрхэн шалгаруулдаг вэ? Ер нь бид хувийн хэвшил цаашдаа өөрөө бие даагаад өрсөлдөөнт зарчмаар ер нь хөгжих тэр боломжийг нь хэзээнээс хангадаг болох юм бэ гэдэг энэ асуултыг асуумаар байна?

2-т нь энэ нэг Баян-Өлгий аймагт нэг ийм аялал жуулчлал, спортын цогцолбор барилга гээд нэг юм ороод ирчихсэн байгаа юм. Тэгээд энэ аялал жуулчлалын чиглэлээр яг ямар юм хийх гээд ийм цогцолбор болгоод явчхав? Энэ дээр тодорхой хариулж өгөөч.

Ховд аймгийн тэр нөгөө нэг Шинэ Ховд гээд нэг аж үйлдвэрийн парк байна. Энэ ер нь өнөөдрийг хүртэл улсын төсвөөс хэчнээн төгрөг зарцуулчихаад байгаа юм бэ, эцсийн өмчлөл нь ер нь хаана байдаг юм бэ энэ Шинэ Ховд төслийн? Тэгээд өнгөрсөн хугацаанд энэ дээр хяналт тавьсан, ямар арга хэмжээ авсан, тийм улсын төсвөөс тавьж байгаа хөрөнгө оруулалт дээр хяналт тавьсан ер нь ямар юм байдаг юм уу, тийм тайлан мэдээ байна уу? Байвал тэрийг харуулж өгөөч гэсэн асуултад хариулж өгөөч.

Р.Сэддорж: Хариулт 7 номер.

Ж.Дэлгэржаргал: Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Төсвийн төсөл дээр ер нь төсвийн хөрөнгө оруулалт бол 2024 онтой харьцуулахад 2 дахин бууруулсан байгаа. Шинэ хөрөнгө оруулалтын тоо 2024 онд 712 байсан бол одоо 149 байгаа. Энэ дотроо тухайн салбарууд яг төсвийнхөө хязгаартаа багтаад нэн тэргүүний чухал, жилийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх гэдэг хүрээнд соёлын салбарт 3 шинэ хөрөнгө оруулалтын 1 нь баруун бүсэд, тэр дундаа Баян-Өлгий аймагт өвлийн аялал жуулчлал, энэ аялал жуулчлалын зорилтуудыг хангахтай холбоотой энэ бүтээн байгуулалтын ажил 8,6 тэрбумаар төлөвлөгдсөн байгаа.

Шинэ Ховд аж үйлдвэрийн паркийн хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аж үйлдвэрийн паркуудын ер нь суурь дэд бүтцийг нь хийж явж байгаа. Энэ дээр Ховдод Шинэ Ховд аж үйлдвэрийн паркийг 2022 оноос эхлүүлсэн. Нийтдээ

ирэх оны төсвийн төсөл дээр тусгасан төслийн хувьд энэ Шинэ Ховд аж үйлдвэрийн паркийн үлдсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд буюу цахилгаан, шугам сүлжээтэй холбоотой, нийтдээ 22 оноос хойш 50 гаруй тэрбум төгрөгөөр энэ суурь дэд бүтэц нь ингээд бүрдээд, 26 онд ашиглалтад орохоор ингэж төлөвлөсөн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2-т зааснаар төсвийн хөрөнгө оруулалт өөрөө орон нутгийн болон төрийн өмчид заавал бүртгэгддэг. Сангийн яам яг эцсийн санхүүжилтийг олгохдоо Улсын комисс хүлээж аваад өмчид бүртгэгдсэн мэдээллийнх нь дагуу санхүүжилтийг олгодог. Тэгэхээр заавал орон нутаг болон төрийн өмчид, аж үйлдвэрийн паркуудын хувьд яг яамны Хөдөө аж ахуйн яамны бодлогын хүрээнд явж байгаа учраас төрийн өмчид бүртгэгдээд, тэн дээр яг энэ суурь дэд бүтэц нь төрийн өмчдөө бүртгэгдээд явна. Хяналтын хувьд төсвийн хөрөнгө оруулалт дээр заавал захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлдэг. Аж үйлдвэрийн паркийн хувьд Барилгын хөгжлийн төв болон орон нутаг захиалагчийн техник, хяналтыг хэрэгжүүлээд, гүйцэтгэл болон санхүүжилтүүдийг баталгаажуулаад явж байгаа.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж нэмэлт мэдээлэл өгье. Хувийн хэвшлийн байгууллагад олгож байгаа ер нь татаасны нийт хэмжээ ирэх оны төсвийн төсөл дээр 2,3 их наяд төгрөгөөр төсвийн төсөлд туссан байгаа. Эндээс 1,5 их наяд нь нийгмийн даатгалын санд олгох татаас байгаа. Тэгээд өндөр дүнгээс нь юу хэлбэл Хөдөө аж ахуйн яам дээр 400 тэрбум төгрөгийн татаас байгаа. Энэ нөгөө арилжааны банкнуудад, банкнуудаас зээл авч байгаа иргэдэд олгож байгаа тэр хүүгийн татаас байгаад байгаа. Мөн Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцаас 32 тэрбум төгрөг дууссан байгаа. Энэ бол ирэх жил шинээр хэрэгжүүлэх мөн аялал жуулчлалын зээлүүдийн хүүгийн хөнгөлөлттэй холбоотой зардал туссан байна.

Ер нь яах вэ татаас 2 янзын хэлбэртэй байгаа. Зарим нь төрийн өмчит компани, жишээ нь эрчим хүчний татаас бол шөнийн үнэ тарифын хөнгөлөлт төрийн өмчит компаниуд руу явчхаж байгаа. Тэгэхдээ иргэдийн үйлчилсэн үйлчилгээнд дээр. Нөгөө талдаа хууль нь юу гэж заасан бэ гэхлээр тарифыг зохистой хэмжээнд байлгах зорилгоор, нөгөө талдаа шөнийн тэр халаалтын асуудлаа цахилгаанаар шийдэхийг нь урамшуулах зорилгоор олгож байгаа. Мөн төрийн өмч, орон нутгийн төсөв дээр төрийн өмчит автобус компаниудад энэ татаас олгодог. Мөн тэр билетийг нь зохистой хэмжээнд үнийг нь тогтоох зорилгоор олгож байгаа. Ер нь хэзээ энэ хувийн хэвшлийн өрсөлдөөнийг бид зөв зохистой хэмжээнд аваачих вэ гэхлээр бид энэ татааснууд дээрээ л зохистой тийм дүн шинжилгээ хийх ёстой. Тэгээд яг энэ тавьсан зорилго, зорилтоо гаргаж ирээд 1 дүгээрт, 2 дугаарт тэр зорилтдоо хүрснийх нь дараа л энэ татааснуудыг зогсоогоод явахад боломжтой гэж хэлэхээр байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Бямбасүрэн гишүүн тодруулж асууя.

Ш.Бямбасүрэн: 2024 оны төсөвт 712 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн гэж хэлж байна. Энэ ирэх оны төсөвт болохоор 149 арга хэмжээ гэж байна. Тэгээд яалт ч байхгүй нэг манай Монгол Улсын төсөв ийм болчхоод байгаа юм л даа. Сонгуулийн жилд ингээд баахан ажил төлөвлөөд тавьчихдаг. Тэгээд одоо тэрнээсээ гарч чадахгүй шинэ хөрөнгө оруулалт хийж чадахгүй болчихдог. Энэ циклээсээ гарах ёстой. Сангийн яам энэ дээр бүүр хатуу байх ёстой гэдгийг цааш цаашаа анхаарч ажиллаарай. Өмнөх Байнгын хороон дээр хэлж байсан.

Тэр Шинэ Ховд төсөл дээр тэр opendata дээр байгаа мэдээллийг нь харахаар төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой гээд ахиад нэг баахан хувийн ААН-үүд байгаагаар харагдаад байгаа. Тэгээд бид тэр ААН-үүдийг яаж сонгон шалгаруулсан юм бэ? Ер нь бид тэд нарын оролцоо нь ер нь юу юм, хариуцлага нь бас юу байх юм гэдэг дээр та нар ямар дүн шинжилгээ хийсэн юм бэ?

Р.Сэддорж: 7 номер хариулна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа төслүүдийн хувьд яг хувийн хэвшил гүйцэтгээд, хүлээж авах нь яг түрүүний хэлсэн орон нутаг бол төрийн өмчид хүлээж авна. Бидний авсан мэдээллээр Ховд аймаг өөрөө яг энэ аж үйлдвэрийн парк байгуулахтай холбогдуулаад Шинэ Ховд аж үйлдвэрийн паркаа орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулсан гэж ойлгосон. Тэгэхээр цаашдаа энэ бүтээн байгуулалтууд хийгдээд, энэ дээр нөгөө үйлдвэрүүд байгуулаад явахаар энэ орон нутгийн өмчит аж ахуйн нэгж өөрөө зохион байгуулалт, менежментийг хариуцахаар ийм бүтэц зохион байгуулалттай. Энэ нь өөрөө энэ орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нь одоо төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төслүүдийг гүйцэтгэж байгаа, хэрэгжүүлж байгаа гэсэн үг бол биш, яг тэрийг цаашаа авч явах менежменттэй холбоотой гэж мэдээлэл авсан.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Бямбасүрэн гишүүн.

Ш.Бямбасүрэн: Би нэг юу яахгүй, энэ дээр opendata руу ороод харахаар Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорац гэх орон нутгийн өмчийн оролцоотой нэг ХХК байна. Хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг нь харахаар 14 хоршоо нэртэй хувийн ХХК-иуд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энэ рүү ингээд улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийгээд байгаа нь зөв юм уу, буруу юм уу л гэдгийг ер нь асуугаад байгаа юм.

Р.Сэддорж: Хариулт 7 номер. Энэ нөгөө цаг өгөхдөө заавал нөгөө тэгж хэлж өгч байгаа, хариулт хангалтгүй гэж үзэж 1 минут өгч байгаа.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад нэмэлт мэдээллийг өгье. Тэгэхээр одоо төсөл хэрэгжиж байгаа Ховд аймгийн хувьд яг энэ Шинэ Ховд аж үйлдвэрийн парктаа тусгайлан газар гаргаад өгчихсөн. Тэн дээр бид дэд бүтэц, зам талбай, мэдээлэл харилцаа, холбоо, цахилгааны ажлуудыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа. Тэгэхээр газар болон одоо тэнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтууд бол тэр корпорац руу өмч шилжээгүй байгаа. Яг төсөл бүрэн дуусаж байж бид Өмчийн тухай хуулиараа энийг өөрөө Хөдөө аж ахуйн яам төрийн өмчдөө бүртгэгдээд ингээд үйл ажиллагаа нь явах юм.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Уянга.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Сангийн яамнаас асуулт асууя. Хөрөнгө оруулалтын төсөвт Төсвийн тухай хуулийн 29.4-өөр эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана, бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэж заасан байгаа. Тэгэхээр яг энэ хөрөнгө оруулалтын төсөл дээр энэ ТЭЗҮ нь хийгдээгүй, зураг, төсөл нь гараагүй яг хэдэн төсөл байгаа юм бэ? Авсан мэдээллээр аудитын тайлан дээр болохоор юу харагдаж байсан бэ, өчигдөр бид Байгаль орчны байнгын хороон дээр Лувсанжамц гишүүний гарсан саналын дагуу араас нь мэдээллүүдийг нь харж үзсэн юм. Цаг уурын харуулын барилга гэнэ, Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд гээд. Энэ нь болохоороо Төсвийн тухай хуулийн 29.4-д заасан энэ шаардлага

хангаагүй байна гээд аудитын дүгнэлттэй. Дараа нь дотуур байрны барилга гээд Сүхбаатар, Халзан сум. Ерөөсөө энэ ажлуудыг хэрэггүй гэж байгаа зүйл биш. Гэхдээ Төсвийн тухай хуулийнхаа 29.4-ийг барихгүйгээр яаж энэ ажлууд төсөвт туссан байх вэ? Тэгэхээр Сангийн яамнаас яг эндээс гадна энэ 2 төслөөс гадна, өөр хэдэн төсөл дээр Төсвийн тухай хуулийн 29.4-ийн шаардлага хангаагүй байгаа вэ? Энэ хариултыг аваад, тэгээд тодруулъя.

Р.Сэддорж: Хариулт 7 номер.

Ж.Дэлгэржаргал: Уянга гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр төсвийн төсөл дээр нийтдээ 149 шинэ төслийн 71 нь яг эдийн засгийн ангиллаараа барилга байгууламж, бүтээн байгуулалтын ангиллын төслүүд байгаа. Тэгэхээр энэ 71 төслийн хувьд яг энэ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл бүхэлдээ төсвийн хөрөнгө оруулалтын тавигдах шаардлага, энийг хангаж ингэж оруулж ирж байгаа. Таны дурдсан төслүүдийн хувьд бол аудитын дүгнэлт дээр нийтдээ ийм 5 төслийг ТЭЗҮ, зураг төсөв гэдэг асуудлыг хөндсөн. Аудит хийх явцад холбогдох байгууллагуудаас тодорхой мэдээллийг дутуу гаргаж өгснөөс үүдэлтэй гэж Сангийн яам үзэж байгаа. Учир нь харуулын байрны хувьд нийт өртөг нь 388 сая, 8 ширхгийг хийнэ, 50 хэд нь 35-аас 50 сая төгрөгөөр баригддаг нэг маягийн зураг төсөвтэй. Тэгэхээр нэг маягийн зураг төсөв буюу яг энүүгээр бид суурилж төлөвлөж байгаа.

Халзан сумын дотуур байрны хувьд 2022 оны магадлалтай. 3 дахь төсөл нь Хавдрын эмнэлэг байгаа. Хавдрын эмнэлгийн хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,4 тэрбумаар ТЭЗҮ, зураг төсвийг нь хийгээд, 24 оноос хойш хийгээд, одоо магадлал гарах шатандаа явж байгаа. Энэний хувьд яг магадлал нь эцэслэж гараагүй. 576 тэрбумаас бид 234 буюу 2 блокийг эхлүүлэхээр төлөвлөсөн. Магадлал гараагүй асуудал нь стандартын асуудал үүссэн.

Дараагийн төсөл КОП 17-той холбоотой байгууламжийн төсөл байгаа. Энэ өөрөө худалдаж авах байгууламж учраас ТЭЗҮ, зураг төсөв хийгдэхгүй. Яг энэ нөгөө үнийн саналаараа байгууламжийг худалдаж авах ийм төслүүд байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой ийм 5 төслийг дүгнэсэн байсан. Тэгэхээр Сангийн яамны хувьд яг нийт ирсэн санал өөрөө 11 их наядын шинэ санал ирсэн, өргөн барьсан төсөл өөрөө 1 их наяд. Тэгэхээр бид энд одоо тусгасан төслүүд маань хуулийн шаардлагаа хангасан, хөгжлийн бодлогынхоо зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ийм тэргүүн эрэмбийн төслүүд байгаа.

Р.Сэддорж: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Аудитынхнаас байгаа тийм ээ, аудитынхнаас байна уу? Аудитынхнаас яг энэ хариултад, асуултад хариулт авъя. Танай тайлан дээр, танай дүгнэлт дээр болохоороо ТЭЗҮ, зураг төсөл байхгүй 29.4-ийн шаардлагыг хангаагүй гэсэн байна. Сангийн яамнаас болохоороо шаардлагыг нь хангасан гэж байна. Яг аль нь үнэн юм бэ?

Р.Сэддорж: 5 номер.

Д.Энхболд: Үндэсний аудитын газар Энхболд Гүйцэтгэлийн аудитын газрын захирал. Уянга гишүүний асуултад хариулъя. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 149 шинэ арга хэмжээнээс Үндэсний аудитын газар нийт 78 барилга байгууламжийн 5 төсөл, арга хэмжээг төсөвлөлтийн шаардлага хангаагүй

гэж дүгнэсэн байгаа. Үүнд саяын Сангийн яамны дурдсан 5 арга хэмжээ бол төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөв, зураг төсөвгүй нь шаардлага хангаагүй байсан. Энэ Сүхбаатар аймгийн Халзан сумын хувьд сүүлийн 2 жилд магадлалаар баталгаажсан дүгнэлттэй байх ёстой энэ шаардлагыг хангаагүй 22 оны дүгнэлттэй байгаа. НҮБ-ын КОП 17 бага хурал зохион.../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмж хариулья 5 номер.

Д.Энхболд: КОП-ын төсөл, арга хэмжээнүүд шууд худалдан авах тоног төхөөрөмж, майхан асрын хэлбэртэй ийм байгууламжууд учраас магадлалаар орох шаардлагагүй гэдэг ийм тайлбарыг өгсөн боловч манайхаас энэ дээр зайлшгүй ийм зураг төсөл байх ёстой гэдэг ийм шаардлагыг тавьсан байгаа.

Р.Сэддорж: Уянга гишүүн хариулт хангалтгүй гэж үзэж байна. 1 минут.

Д.Энхболд: Тэгвэл Аудитын газраас энэ 5 төсөл, КОП-ыг бүүр орхиё. Тэгвэл тэр 3 төсөл нь болохоороо Төсвийн тухай хуулийн 29.4-ийг хангаагүй гэж үзсэн юм байна. Тэгэхээр мэдээж аудитынханд л итгэх ёстой байх л даа. Тэгэхээр Учрал сайд байна уу? Одоо тэгээд энэ 3 төслөө яах юм бэ, 26 онд эхэлж амжих уу, гүйцэх үү? Өөр бусад шаардлагатай юмнууд руугаа энэ төслүүдээ шилжүүлэх хэрэгтэй биш үү?

Р.Сэддорж: Эдийн засгийн хөгжлийн яамнаас гараа өргөөрэй. Эдийн засгийн хөгжлийн яам хэн хариулах юм бэ? 7 номер.

Ж.Дэлгэржаргал: 3 төслийн хувьд Хавдрын эмнэлэг бол 26 оны жилийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг, нийгмийн эрэлт хэрэгцээ талаасаа бүх шаардлагууд нь ингээд тавигдчихсан. Яалт ч үгүй тулгамдаж байгаа асуудлын нэг. Халзан сумын дотуур байрны хувьд тэнд хүүхдүүд ингээд яг хичээлийн жилийн хугацаанд амьдрах ямар ч нөхцөл байдалгүй болсон буюу бодит байдал нь төсвийн төсөл дээр 3 ширхэг дотуур байр л байгаа, маш хүндэрчихсэн. Тийм учраас бид 22 оны магадлалаар нь хэрэгжүүлэх боломжтой гэж Боловсролын яам үзсэн учраас тусгасан. Хүүхдүүд тэнд тэр шинэ байрыг барихгүй бол амьдрах аргагүй ийм нөхцөл. Харуулын байрны хувьд та байгаль хамгаалагч нарт зориулсан, тэнд бас яг ингээд ажлаа хийнгээ амьдраад ингээд байгаль хамгаалагчид байдаг ийм л учир холбогдолтой байгаа. Яг одоо зураг төсөвгүй ч юм уу, тооцоололгүй төслүүд огт биш, нэг маягийн зураг, 22 оны магадлал, магадлал нь гарах шатдаа байгаа ийм.../минут дуусав/

Р.Сэддорж: Эдийн засгийн хөгжлийн яамнаас хэн байна вэ? Учрал сайдыг дуудъя. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Оюу толгойн Хянан шалгах түр хороо байгуулагдсанаас хойш 3 сарын хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд бид төрийн байгууллагууд болон ААН-үүд, олон ч байгууллагуудыг дуудсан. Яг өнөөдрийн байдлаар Оюу толгой компаниас 3 удаа дуудаад ирэх боломжгүй гэсэн хариуг авсан байгаа. Тэгээд өчигдрийн мэдээнээс харж байхад эхнээсээ ингээд шалтгаан нь цухуйгаад эхэлж байх шиг байна л даа. Өчигдөр олон нийтийн сүлжээнд гарснаар Тагнуулын ерөнхий газраас Оюу толгойн худалдан авалт, хангамжтай холбоотойгоор 4 албан тушаалтныг албан тушаалаа урвуулан ашигласан, мөнгө угаасан байж болзошгүй хэргээр баривчилгаа явагдсан байгаа юм. Нэг ёсондоо Тагнуулын ерөнхий газраас гүйцэтгэх ажиллагаа явжээ.

Энэ асуудлуудыг гаргаж ирээд ярьж байгаа Хянан шалгах түр хорооныхоо дарга дээр гүйцэтгэх ажиллагаа биш, энэ албан тушаалаа эсрэгээрээ ашиглаж байгаа хүмүүс дээр гүйцэтгэх ажиллагаа явах нь зөв шүү дээ. Үндэсний ашиг сонирхлыг урдаа барих байгууллага бол Тагнуулын ерөнхий газар. Эх оронч хэдэн залуус ажлаа хийж байна л гэж харж байгаа. Хянан шалгах түр хороо Оюу толгойг иртэл нь бас дуудах болно. Парламентыг үл хүндэтгэж болохгүй, Монгол Улсын хууль тогтоомжоор явах ёстой.

Бас яг энэ өдөр Ройтерс агентлагийн мэдээн дээр, гадаадын мэдээн дээр бас нэгэн мэдээ гарсан. Яг энэ хэлэлцээр Рио Тинто, Монгол Улсын Засгийн газар албан ёсоор 27-нд буюу энэ нэг дэх өдрөөс албан ёсоор эхлэх гэж байгаа юм. Рио Тинтогоос маш том баг ирж, Монгол Улсын Засгийн газартай албан ёсоор Онтрэ-ийн асуудал болон зээлийн хүү бууруулах талаар хэлэлцээр эхлэх гэж байна. Хянан шалгах түр хорооны 11 гишүүд бол 3 сар ёстой Байнгын хороо шиг 7 хоног тутам хуралдсаар ямар ч байсан 2 талыг хэлэлцээрийн ширээн дээр суулгалаа шүү. Хэлэлцээр Монгол Улсын эрх ашгийг хангасан асуудлуудыг шийдсэн, харилцан ашигтай ийм хэлэлцээр амжилттай явах ёстой.

Тэгээд тэр Ройтерсын гарсан мэдээн дээр Рио Тинто компанийн 11 хувийг эзэмшигч Chinalco компанид Оюу толгой болон тэр Папуа Гвиней улсын Африкт байгаа Simondou гээд төслөө хувьцаагаараа наймаалцах ийм мэдээ гарч байгаа юм л даа. Яг хэлэлцээр эхлэхээс 4 хоногийн өмнө. Энэ бол ингээд цоо шинэ мэдээ ерөөсөө биш. Ухаад үзсэн чинь 12 онд, 18 онд, 19 онд, 21 онд яг хэлэлцээрт орох үеэр л нэг иймэрхүү мэдээ явдаг. Дарга нэмэлт 1 минут нэмчихье тэгэх үү? Тэгээд маш том үндэстэн дамнасан корпорацтай Монгол Улсын Засгийн газар том хэлэлцээрт орох гэж байна. Хэлэлцээрийн өөрөө том шинжлэх ухаан байдаг. Энэ.../минут дуусав/

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн 1 минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр энэ хэлэлцээрийн шинжлэх ухаан дээр Preemptive Framing Inoculation strategy гэж байдаг. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээрээ хэлэлцээрт орохын өмнө нэг ёсондоо урьдчилсан вакцинжуулалт хийдэг ийм хэлэлцээрийн тактикийн тоглолт явдаг байхгүй юу. Тэгэхээр энэ тоглолтдоо автчихав, том компанитай хэлэлцээрт орж байгаа шүү дээ. Энэ битгий хэл асуудлууд гарна. Тэгэхээр гарч ирсэн асуудал болгонд нь тэгээд л итгэж алдраад л, эсвэл айж ичээд л, авч сэвээд ингээд байж болохгүй. Том хэлэлцээрт баялгийнх нь эзэн нь байна. Өөртөө итгэлтэй орох ёстой. 3,5 сая иргэн нь илүү мэдлэгжсэн, илүү мэдээлэлжсэн, олон түмний анхаарал хандсан энэ үед хэлэлцээрт орж байгаа шүү. Ямар шийдэл гарахыг Монголын ард түмэн 3,5 саяулаа чих тавин, нүд цавчилгүй ширтэж байгаа яг энэ үед хэлэлцээр явж байна. Хэлэлцээрээс заавал.../минут дуусав/

Р.Сэддорж: Хэлэлцэх асуудалтай холбогдоогүй зүйл учраас хариулах шаардлагагүй. Мандхай гишүүн.

М.Мандхай: Энэ өдрийн мэндийг хүргэе. Манайх нөгөө НҮБ-ын КОП 17-той холбоотой чуулган хурал энэ Монгол Улсын хувьд ган, цөлжилт, газрын доройтлын асуудлуудтай уялдсан энэ эх орныхоо ногоон хөгжил, байгаль орчны салбарт тулгамдаж байгаа энэ хүндрэлүүдээ илүү энэ дэлхий нийтэд дуу хоолойгоо өргөх ийм том арга хэмжээ болохоор төлөвлөж байгаа. Гэтэл манай энэ төсөв дээр

байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв 26 тэрбум төгрөгөөр хасагдчихсан байна. Энэ дотор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулалт, агаарын бохирдлыг бууруулах гээд, ургамал хамгааллын бүх асуудлууд үндсэндээ энд орчихсон байгаад байгаа юм. Тэр дотроо бүүр ойжуулалт нь 22,2 тэрбум төгрөгөөр хасагдчихсан байгаа. Тэгэхээр энэ манай үндсэн энэ хөгжлийн хөтөлбөртэй чинь энэ төсөв өөрөө уялдаж байгаа юм уу гэдэг нэг асуулт байгаа. Энийг яагаад ийм зөрөөтэй төсөв тавьж, энэ хамгийн чухал байгаль орчныг хамгаалах арга хэмжээгээ хасчхав гэдэг асуудал байгаа юм?

Мөн хангамж, бараа материалын зардал дээр шуудан холбоо, интернэтийн төлбөр 12,1 тэрбум төгрөг, ном хэвлэл 10 тэрбум төгрөг нэмэгдсэн байгаа. Бусад үйлчилгээний зардал дээр мэдээлэл сурталчилгааны зардал 2018 онд дандаа тэг явж ирж байснаа 2026 онд 20,8 тэрбум төгрөг ингээд нэмчихсэн. Үндсэндээ ингээд нийлээд үзвэл бараг 56 тэрбум төгрөг хэмнэгдэж болох зүгээр зардлыг энэ төсөв дээрээ оруулаад тавьчихсан. Гэтэл бид өнөөдөр багш, эмч, тэтгэврийн нэмэгдлийг өгөх чадамжгүй, боломжгүй гээд сууж байгаа. Тэгтэл энэ чинь яг төсвөө харвал шаардлагагүй зардлууд байна шүү дээ.

Одоо энэ байж байгаа юм. Өмгөөлөл, хуулийн зөвлөлийн үйлчилгээний төсөв, үйлчилгээний хөлс 13,4 тэрбум төгрөг, нэг жилийн дотор, сарын 1,1 тэрбум төгрөг. Энэ ямар үйлчилгээний өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс юм бэ? Энийг тайлбарлаад өгөөч. Уран бүтээл хийлгэх гэж байгаа юм, 400, 500 орчим тэрбум төгрөг, 449 юу, 449 сая төгрөг. Улсын зэрэглэл тогтоох үйлчилгээ гэнэ 174 тэрбум төгрөгөөр өмнөх жилээсээ нэмэгдчихсэн саяар, 934 сая бараг тэрбум орчим төгрөг. Энэ яг ямар үйлчилгээ юм бэ гэдгийг асуумаар байна?

2 дугаарт төрийн өмчит байгууллагын энэ олгох татаас 127 тэрбум, өнгөрсөн 25 онд 88,6 байсан, энэ 26 онд 38,7 тэрбум төгрөгөөр нэмэгдчихсэн байгаа шүү татаас. Тэгэхлээр энэ төрлийн энэ компаниудаа хэзээ цэгцлэх юм бэ? Энэ татаас чинь орлого олдог хэзээ болох юм бэ, ямар ер нь төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм бэ? Энэ татаасыг нэмж олгоод, нийтдээ 38,7 тэрбум төгрөгийн татаасыг энэ төсвийн хүнд нөхцөл байдалд ашиггүй ажилладаг энэ төрийн өмчит байгууллагынхаа татаасыг бид өгснөөрөө дараа ондоо ямар ахиц гарна гэсэн төлөвлөгөөтэйгөөр тавьсан юм бэ? Ер нь яагаад энэ татаасыг нэмсэн юм бэ гэдэг дээр.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 8 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Ном хэвлэлийн зардал гэдэг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар зөвхөн ном хэвлэлтэй холбоотой үндсэн үйл ажиллагаа нь явж байгаа байгууллага буюу номын санд л олгож байгаа номын нөхөн бүрдүүлэлтийн зардал байгаа. Мэдээлэл сурталчилгааны зардал гэдэг бид бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж гээд энэ эдийн засгийн ангиллыг хэт ерөнхий байна гэдэг шүүмжлэл гараад, тэгээд Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу шинээр зардлуудыг нь нарийвчилж тодотгосон. Үүнтэй холбоотойгоор мэдээлэл сурталчилгааны зардал шинээр огт байгаагүй байж байгаад тавигдсан учраас нэмэгдэж байгаа юм шиг харагдаад байгаа. Тэрнээс өмнө нь бол суурь нь байгаа гэсэн үг.

Дараагийн ээлжид төрийн өмчит байгууллагуудын татаас гэдэг дээр хамгийн өндөр татаас нь түрүүн би дурдсан нийгмийн даатгалын санд олгож байгаа ахмадын тэтгэврийг тавихад дутагдаж байгаа алдагдлын татаас бол гол нөлөөтэй байгаа. 2

дугаарт орон нутгийн байгууллагууд дээр байгаа автобус компаниудад олгож байгаа энэ автобусны билетийг тодорхой зохистой хэмжээнд барихад зориулсан татаас байгаа. 3 дугаарт эрчим хүчний татаас байгаа. Шөнийн тарифын хөнгөлөлт буюу шөнийн цагаар тухайн айл өрхийг нүүрсээр биш цахилгаан халаагуураар тэр халаахад зориулж хөнгөлөлтүүдийг олгож байгаа ийм зүйл байгаа.

Нөгөө талдаа бид зардлууд буурч байгаа. Энэ буурах хэд хэдэн шалтгаантай асуудлууд байгаа. Энд хамгийн гол асуудал бид ер нь орлого, орлогодоо нийцсэн ийм зарлага л бид тавьж явахаас өөр аргагүй. Тэгэхлээр сая энэ 26 оны төсвийг бид өргөн барихад автоматаар нэмэгдэх шаардлагатай дүн 1 их наяд төгрөг гарчхаад байгаа, хүүхдийн тооны өсөлт, ахмадын өсөлт гэх мэтээр. Энэ өсөлтийг 1 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа боловч урсгал зардал нөгөө талдаа 585 тэрбум төгрөгөөр л өсөж байгаа. Тэгэхлээр зөрүүлээд энэ 400 гаруй тэрбум төгрөгийг бид хасахаас өөр аргагүй болж байгаа. Хасах боломжтой хамгийн боломжтой хувилбараар нь Засгийн газар хасах боломжтой байна гээд л оруулж ирсэн ийм төсөв болчихож байгаа. Хариулж дууслаа, баярлалаа.

Р.Сэддорж: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Яам яг, би одоо сайн ойлгохгүй байгаад байх юм. Эсвэл бидэнд ийм төсөв, төсвийн номыг бидэнд бэлдэж өгөхдөө ийм ойлгомжгүй байдлаар бэлдэж өгдөг юм уу, эсвэл биднийг төөрөгдүүлэх маягаар ингээд тайлбар хэлээд байдаг юм уу? Энэ дээр ингээд ном хэвлэлийн зардал чинь 2025 онд 1,1 тэрбум төгрөг байсан байхгүй юу, мэдээлэл хангалтгүй байна гээд хэлж болно. Тэгэхдээ энэ төсөв хэмнэх ийм төлөвлөгөөтэйгөөр 26 оны төсвийг оруулж ирэхдээ яахаараа ном хэвлэл дээр 10 тэрбум төгрөг болгож нэмдэг юм бэ? Энэ чинь логикийн хувьд угаасаа зохицохгүй байна шүү дээ. Тэр байтугай бид хэмнэх, төсөв хэмнэх гэж байгаа бол ялангуяа энэ мэдээлэл сурталчилгаа, ном хэвлэл, энэ шуудан холбооны зардал чинь илүү хэмнэгдэх ёстой биз дээ? Хамгийн хэмнэж болох төсөв байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр ингээд төсөв дээр чинь улайм цайм тэг энэ мэдээлэл сурталчилгаа.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 8 номер.

М.Санжаадорж: Ном хэвлэлийн зардал би түрүүн дурдсан Хэмнэлтийн хуулиараа ганцхан газар ном хэвлэлийн зардал байх боломжтой. Тэр нь номын сан. Ирэх жил Төв номын сангийн шинэ барилга бүрэн утгаараа ашиглалтад ороод баригдахаар үүнтэй холбоотойгоор тодорхой хэмжээнд зардал нь нэмэгдэж байгаа. Цахимжуулалттай холбоотой зардлууд бол мэдээж хэрэг бас нэмэгдэж байгаа. Одоо энэ дээр хэрвээ хасах та санал гаргавал та зүгээр хасах саналаа гаргаад явчихад мэдээж хэрэг гишүүнийхээ эрхийн хүрээнд бүрэн эрх байгаа. Бидний хувьд зүгээр энэ зардлын цаад агуулгыг нь л тайлбарлах ийм үүрэгтэй байгаа.

Р.Сэддорж: Мандхай гишүүн хариулт хангалтгүй, болчихсон уу? Улсын Их Хурлын гишүүн Ганзориг.

П.Ганзориг: Би нөгөө нэмэлт цагаа авч байгаад асуучихъя. Энэ Үндэсний баялгийн сангийн үлдэгдэл 2026 оны эцсийн байдлаар 2,2 тэрбум долларт хүрэхээр ийм төсөөлөлтэй байгаа юм байна. Тэгээд манай Монгол Улс төсвөө алдагдалтай төсөв батална, дээр нь алдагдалтай төсвөө гадаадын өндөр хүүтэй зээл, тусламжаар санхүүжүүлдэг. Нэг талдаа энэ баялгийн сангийн маань өгөөж энэ танилцуулгаас харж байхад 4 орчим хувьтай байна өгөөж нь. Тэгээд энэнээсээ

бараг 2 дахин өндөр хүүтэй зээл авч байгаа. Тэгэхээр энэ Засгийн газрын ер нь гаднаас авч байгаа зээл, тусламжийн жигнэсэн дундаж хүү ямар байгаа вэ? Энэ баялгийн сангийн өгөөжтэй энийг харьцуулбал яаж уялдуулж явбал зүгээр вэ?

Засгийн газраас 2025 оны 72 дугаар тогтоолоор энэ Баялгийн сангийн хөрөнгийг гаднын харилцагч банкны төв банкны нөгөө харилцах дансанд байршуулна гээд тавьчихсан. Энэнээс өөрөөр энэ Баялгийн сангийнхаа хөрөнгийн удирдлагын менежментийг сайжруулах ийм боломж байгаа юу, үгүй юү? Нэг талдаа манай Монгол Улс валютын нөөц багатай, мөнгөн хөрөнгө багатай. Тэгээд нөгөө талдаа уул уурхайгаасаа олж ирсэн жоохон хуримтлалаа гадаадын банканд аваачаад маш бага хүүтэй тавьчихдаг. Буцаагаад зээл авах болохоороо тэрнээсээ 2 дахин өндөр хүүтэй авдаг ийм асуудал байна. Энэ дээр ямар бодлого уялдаа байгаа вэ 1-д?

2-т энэ Баялгийн сангийн үлдэгдэл чинь гадаад валютын нөөц тооцогдож байгаа юу гэдгийг тодруулмаар байна?

3-д өнгөрсөн 2024 оны төсвийн гүйцэтгэл дээр Үндэсний аудитын газраас аудит хяналт шалгалт хийгээд 9,2 их наядын зөрчил илэрсэн гээд танилцуулж байсан. Бараг нийт урсгал зардлын чинь 50 хувь зөрчилтэй. Энэ дотор чинь нөгөө сангийн зардлууд явж байгаа. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангууд, өмнө нь банканд тавиад алдчихсан зүйлүүд. Тэгэхээр энэ ирэх жилүүдэд энэ сангийнхаа асуудлын хяналт, үр ашиг сайжруулалтыг яаж хийхээр тооцож байгаа вэ?

Үндэсний аудитын газраас 4 дэх асуулт, энэ гүйцэтгэлийн аудит хийхдээ энэ томоохон төслүүд дээр гүйцэтгэлийн аудит хиймээр байна. Тухайлбал 2022 онд хийгдсэн төмөр замын Бодь групптэй хийсэн гэрээ байж байгаа, 1,2 тэрбум доллароор гэрээ хийгээд, улсын нууцад авчихсан. Тэгээд тэр нь зах зээлийн бодит өртгөөс бараг 2, 3 дахин өндөр гэж тухайн үед мэргэжлийн хүмүүс хэлж байсан. Тэгээд иймэрхүү зүйл дээрээ болохоор хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргахгүй, ямар ч тендергүй авчихсан гэрээ шүү дээ, 1,2 тэрбум доллар чинь бараг 4, 5 их наяд гэсэн үг. Тэгээд жилийн улсын төсөв дээрээ нээлттэй тендер зарлаад, хэдэн зуун компани, хэдэн мянган компани өрсөлдөөд авснаа болохоор хянаад, шалгаад, төсөв мөнгийг нь хасаад яваад байдаг. Тэгээд энэ бодлогыг ямар, энэ дээр ямар бодлого барьж ажиллах вэ? Тэр томоохон төсөл хөтөлбөрүүд нууцад авсан зүйлүүд дээр хяналт шалгалтууд.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 8 номер.

С.Тулга: Сангийн яам Тулга. Гишүүний асуултад хариулъя. Би нөгөө баялгийн сантай холбоотой хэсгийг нь хариулъя. Баялгийн сангийн одоогийн үлдэгдэл 1,2, 1,3 тэрбум ам.доллар нь одоогийн Төв банкны валютын нөөцөд орж байгаа. Өөрөөр хэлбэл 5,7-ийн 1,3 нь Ирээдүй өв сангийн хөрөнгө байгаа. Ирээдүй өв сангийн тухай хууль болон Үндэсний баялгийн сангийн тухай хуульд энэ Ирээдүй өв сангийн хөрөнгийг удирдахдаа сангийн хөрөнгийг найдвартай, дараа нь хөрвөх чадвартай энэ 2 нөхцөлийг зэрэг хангасны үндсэн дээр ашиг өгөөжийн зохистой түвшинд удирдана гэж заасан байгаа. Энэ хүрээнд хамгийн түрүүнд бид хойч үедээ өвлүүлж байгаа энэ хөрөнгийг найдвартай байдлыг хангаж байгаа.

Тэгэхлээр Англи, Люксембург, Франц гээд доод тал нь А+ зэрэглэлтэй энэ улсуудын Төв банкин дээр бид хөрөнгийг байршуулж байгаа. Манай улсын хувьд манай улсын зэрэглэл нэмэгдээд В+ байгаа. Тэгэхлээр бид илүү нөгөө нэг бага

зэрэглэлтэй, өндөр өгөөж авах ийм юу руу оруулж болно. Гэхдээ хуулиар биднийг яаж байгаа юм бол энэ хөрөнгийг бид найдвартай хадгалах ёстой. Тэгээд 4,1-ээс 4,3 хувийн хүү өгөөж гэдэг маань одоо ерөнхийдөө Америкийн төв банкны үнэт цаасны хэмжээнд байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Дараагийн хариулт 9 номер. Өөрсдийнхөө албан тушаалыг хэлээрэй.

3.Цэдэнжав: Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч. Ганзориг гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллага хуульд заасны дагуу, хуулийн дагуу хийх аудит болон бодлогоор хийх аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулж байгаа. Бид ингэхдээ иргэд, олон нийтийн үнэн зөв хариу хүссэн асуудлууд болон иргэд олон нийтээс Засгийн газрын 11 11 төв болон ИМонголиа платформоор ирсэн саналуудыг нэгтгэн дүгнэж, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудитор Төсвийн байнгын хороонд саналаа хүргүүлж байгаа. Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүдийн саналыг Байнгын хороодоор дамжуулаад аваад, төлөвлөгөөгөө батлуулаад ингээд ажиллаж байгаа. Энэ томоохон төсөл, хөтөлбөрүүдтэй холбоотой асуудал дээр төрийн аудитын байгууллага аудит хийж байгаа. Тухайлбал Оюу толгой.../минут дуусав/

Р.Сэддорж: 9 номер гүйцээгээд хариулчихъя 1 минут.

3.Цэдэнжав: Тухайлбал Оюу толгой төслийн болон Тавантолгой төмөр замын асуудалд аудит хийгдээд явсан. Энэ Оюу толгойн энэ саяын Хянан шалгах хороонд манай алба хаагчид оролцоод ингээд явж байгаа. 26 оноос эхлээд төрийн аудитын байгууллага бодлогын хувьд энэ улс орны эдийн засгийн, эдийн засаг, нийгэмд томоохон хувь нэмрээ оруулах энэ мега гэж байгаа, мега төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл болон энэ хууль тогтоомжийн нийцлийн байдалд бид урьдчилсан байдлаар урьдчилсан аудитыг хийхээр төлөвлөөд, бид төсвийн саналаа, төлөвлөгөөний саналаа Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байгаа гэдгийг дуулгая.

Р.Сэддорж: Ганзориг гишүүн тодруулж асууж.

П.Ганзориг: Энэ Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн байршуулалттай холбоотой Монголбанк мэдээж энийг гадаад валютын нөөцдөө оруулдаг болохоор тэгээд л нэг гаднын Төв банканд найдвартай гэдэг агуулгаар нь хадгалаад л сууж байна шүү дээ. Тэгэхдээ энэ Эдийн засгийн хөгжлийн яам Монгол Улсын энэ баялгаа үр ашигтай яаж өсгөж авч явах вэ гэдгээ бодолцож, энэ дээр тэр бусад орны баялгийн сангуудын хөрөнгө оруулалтын хэлбэрүүд, менежментийн арга хэлбэрүүдийг авч явахгүй юм уу? Тэгээд өөрсдөө мөнгө хөрөнгө багатай зээл, тусламжаар төсвөө санхүүжүүлж явж байж, байгаа хөрөнгөө аваачаад найдвартай гээд бага хүүтэй байршуулчихаад, тэрнээсээ 2 өндөр, 2 давхар өндөр хүүтэй юм аваад байх нь ер нь зохимжгүй байгаа. Энийг ер нь цаашид бодлогоор анхаарах ёстой. Их Хурлаас ч анхаарна, холбогдох энэ Эдийн засгийн яам болоод Монголбанк анхаарч явах ёстой байх гэдэг зүйлийг тодруулж хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Зөвхөн улсын төсөв, орон нутгийн төсөвт найдахаас гадна байгалийн баялгийн өгөөжөөс орж байгаа энэ Үндэсний баялгийн сангийн хуулийг амилуулах, энэний үр өгөөжийг ард иргэдэд хүргэх гэдэг асуудал бид төсөвтэй хамт маш чухал авч явж байх ёстой асуудал байгаа. Тэгээд би саяхан энэ газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутагт нь олон улсын зарчмын дагуу хуваарилах тухай хуулийн төслийг зүүн бүс, говийн бүсийн гишүүдтэй хамт санаачилж, Засгийн газраас санал авсан юм. Тэгээд энэ дээр бас тэгээд л 3 асуудлаар дандаа болохгүй гэсэн юм ирүүлсэн байна лээ. Тэгээд би юу гэж хэлэх гээд байна гэхээр гүйцэтгэх засаглал энэ аливаа зүйлийг ингээд хөгжил дэвшил рүү тэмүүлэх, энэ гол гацаа үүсгээд байгаа, тохируулга хийх шаардлагатай улс өөрөө хууль, эрх зүйгээрээ энийг зохицуулах шаардлагатай энэ зүйлүүд дээр нэг болгох талаас нь саналаа өгөх энэ зүйл рүү ийм огцом реформ хийхгүй бол тэгээд миний ойлгож байгаагаар нэг тийм байгууллагын нэг нярав шиг, тэгээд падаан бүрэн, өр ширэнд орохгүй, тэгээд нэг хариуцлага алдахаас айсан ийм байдалтай ер нь дандаа энэ хуулийн төсөлд санал өгдөг юм байна лээ.

Би ер нь хуулийн төсөл болно, энийг нэг ингэчихье гэдэг ийм өгч байгаа юм бол маш цөөн байгаа гэж бодож байгаа. Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна гэхээр дараагийн 2 дахь хууль нь энэ Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүдийн хамт бид санаачлаад ингээд Засгийн газраас санал авахаар хүргүүлчихсэн байгаа. Ээ дээ энэ хүүхдийнхээ төлөө энэ хууль дээр нэг болох талаас нь саналаа өгөөрэй. Тэгээд энэ Үндэсний баялгийн сантай уялдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл Үндэсний баялгийн сангийн Ирээдүйн өв сангийн валют хэлбэрээр хадгалж байгаа энэ хөрөнгийг өөрөөр хэлбэл санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар хүү бодож арвижуулж байгаа энэ арвижуулсан хүүгийнх нь 50-аас доошгүй хувийг хүүхдүүдийнхээ хөгжилд зориулъя гэдэг ийм Баялгийн сангийн хуульд нэг заалтад нэмэлт оруулж, тэгээд Хүүхдийн хөгжлийг дэмжих анхдагч хуулийг ингэж боловсруулж явж байгаа юм. Тэгээд энийг би Засгийн газраас гүйцэтгэх засаглалаас та бүхнээс би хичээнгүйлэн хүсье.

Энэ уул уурхайн баялаг гэдэг чинь ирээдүй үеэсээ бид зээлж хэрэглэж байгаа баялаг гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй эхлээд. Тийм учраас энэ дээр болох талаас нь санал өгөөрэй гэдгийг би бүүр хичээнгүйлэн ард түмнийхээ өмнөөс, ирээдүй хойчийнхоо төлөө өмнөөс хүсэж байна. Хэрвээ ингээд хүсээд байхад болох талаас нь ирүүлэхгүй бол энийг дараагийн чуулган дээр илүү яагаад татгалзсан гэдэг талаар тэр тухайн албан тушаалтантай нь ярих нь зөв гэж үзэж байгаа. Ер нь ард түмэн үнэнийг мэдэх хэрэгтэй гэж.

3-д нь энэ жижиг, дунд бизнесийг дэмжих талаар. Энд мөн хуулийн төсөл боловсруулаад явж байгаа Засгийн газраас санал авна. Энэ дээр болох талаас нь.../минут дуусав/

Р.Сэддорж: Тодруулж асуух юм уу? Үгүй ээ, хариулсны дараа, хариулт, хариулт хэн байна вэ? Аль яамнаас хариулах вэ? Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Жижиг, дунд үйлдвэрлэлийн одоо байгаа сан чинь ингээд 300 сая хүртэл төгрөгт л өгдөг байхгүй юу. Тэр чинь бичил гэж ангиллаар орж байгаа юм. Бичилд өгдөг боловч тэр нь жижиг, дунд сан нэртэй. Энийг Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих корпорацыг тусад нь байгуулах хэрэгтэй. Харин энийг яаж санхүүжих вэ гэхээр Үндэсний баялгийн сангийн хөгжлийн санд төвлөрч байгаа хөрөнгийн 50-аас доошгүй хувийг энэ сан руугаа буцаж оруулж, жил болгон энэ

сангаа арвижуулдаг байх ёстой. Өөрөөр хэлбэл далай яагаад том байдаг юм гэхээр гол, горхи өчүүхэн жижиг гэж голохгүй хүлээж авдагтаа том байдаг. Тэрэнтэй адилхан энэ сан чинь ингэж өөрөө нэмэгдэж жил болгон нэмэгдэж явж байх ёстой болохоос биш нэг, ганц нэг хэдэн төгрөг нэг төсвөөс нэг удаа гаргачихъя ингээд болохгүй. Тэгэхээр энэ дээр болох талаас нь саналаа өгөөрэй. Энэ боломжтой юу? Энэ 2 гэдэг дээр би Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, мөн Монголбанк эндээс хариулт авъя.

Р.Сэддорж: Сангийн яам. Сангийн яам хаана байна вэ? Ганбат дарга. Хууль зүйн яам. Хэрэг эрхлэх газраас хэн байна вэ? Эдийн засаг, хөгжлийн яам Батхүү дарга 5 номер.

И.Батхүү: Саяын дурдсан асуудал том агуулгаараа эдийн засгийг төр хувийн хэвшлийг дэмжих агуулгаар манай яамны зүгээс бодлогын судалгаа хийгээд, баримт нотолгоонд суурилсан дүгнэлт гаргаад цаашдаа ажиллахад бэлэн байгаа. Энэ асуудал хариуцсан яамнууд нь салбарын өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлын үр дүн, авч хэрэгжүүлсэн асуудлуудынхаа цаашдын үр дүнтэй эсэх, цаашид үргэлжлүүлж хэрэгжүүлэх эсэх дээр ямар бүтцээр явуулах эсэх дээр дүгнэлтээ гаргаад, манай яамтай хамтраад ажиллахад бэлэн байгаа.

Р.Сэддорж: Сангийн яам 7 номер. Санжаадорж дарга 8 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. 3 асуудал ярьж байгаа юм байна. 3 асуудалтай холбоотойгоор Сангийн яам дангаараа шууд байр сууриа илэрхийлэх боломжгүй. Гишүүний асуултын санаачилсан хуульд хуулийн дагуу 10 хоногтоо багтаагаад, Хууль зүйн яамнаас бол манайхаас санал авахаар бичиг ирүүлдэг. Тухайн үед нь бид яг түрүүний Батхүү даргын хэлсэнчлэн судалгаа нотолгоонд үндэслэсэн байдлаар бид судалж байж, саналаа танилцуулж байж саналаа хүргүүлдэг. Тэгээд Засгийн газар кабинетын зарчмаар олонхын зарчмаар шийдвэрээ гаргаад ингээд саналаа хүргүүлдэг байгаа. Тийм. Одоо бол шууд хариу хэлэх боломжгүй байна.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзсэн 1 минут Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Энэ айлаас ирэхээр авдраа уудал гэж энэ төсөв баялгийн санд байгаа хөрөнгөө яаж үр дүнтэй өрх айл, жижиг, дунд бизнесийг энэ ажил эрхлэх боломжийг нь олгох вэ гэдэг л хамгийн чухал байхгүй юу. Иргэн баян улс баян гэж байгаа юм. Хүний хөгжил бол хүүхдээс эхэлнэ. Тэгээд энэ 2 салбартаа хандсан бодлогыг одоо байгаа Баялгийн сангийн нөөц боломж дээр тулгуурлаад, төсвийн бодлоготойгоо уялдуулаад, тэгээд ингээд хэрэгжүүлээд явахгүй бол болохгүй гээд яваад байвал хэзээ ч болохгүй. Хэзээ ч хүүхэд чинь хөгжихгүй, хэзээ ч жижиг, дунд бизнес чинь томрохгүй, тэгээд нүүрсний хулгайгаа яриад л яваад байна. Тэгэхээр энийг яаж энэ хүүхдүүдийг эрдэм боловсролтой, эх оронч, зүтгэлтэй, өөртөө хариуцлагатай байх, жижиг, дунд бизнес эрхлэгч нь бусад орнуудын жишгийн дагуу татварын бааз суурьт өндөр хувь эзэлдэг, цаашид өсөн томордог, хүн бүр хийж чаддаг юмаа хийдэг.../минут дуусав/

Р.Сэддорж: Сангийн яам 8 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж, гишүүний асуултад хариулъя. Таны саяын хэлсэн асуудлууд холбогдох салбарын асуудал хариуцсан яамнууд нь хариулна. Манай яамны хувьд Ирээдүй өв сан бол манайд харьяалагдана. Ирээдүй

өв санг бид зарцуулахын эсрэг байгаа. Энэ мөнгийг бид арвижуулж хадгалах ёстой. Энэ маань өөрөө Монгол Улсын зээлжих зэрэглэлд хамгийн ихээр нөлөөлж байгаа. Нөгөө талдаа бид гадаад зээлээ нэмэгдүүлэх бодлого барьж байгаа. Энэний цаад шалтгаан нь байгаа зүйлээ идээд дуусчих биш, харин зах зээлээ бид яаж томруулах вэ, дотоодын нийт бүтээгдэхүүнээ яаж томруулах вэ энэ нь эргээд хувийн хэвшлээ яаж дэмжих вэ гэдэг ийм бодлого явж байгаа шүү.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Монголбанкнаас байгаа юу? Монголбанкнаас байвал асуулт асуумаар байна. Статистикийн газраас асууя. Инфляц яг хэд байна вэ, Улаанбаатар хотод хэд байна, улсын дундаж хэд байна, оны сүүл рүү хэд болох гэж байна вэ? Энийг асуумаар байна. Энэнээс хамаараад маш олон зүйл дагаж хөдлөх гээд байгаа учраас.

Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг ингээд урсгал зардал дотор оруулж тооцоод, тэгээд баахан улс төрийн шийдвэрээр аваачаад нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлэхгүй баахан албан хаагчдын өмнөөс төр төлнө гэж байгаа тэрийгээ Нийгмийн даатгалын санд татаас гэж гадаад талдаа ойлгуулаад, тэгээд урсгал зардал дотоодын нийт бүтээгдэхүүнд 24 хувь байна гэдэг нэг юм хийгээд, түүний чинь бараг үндсэндээ бараг 8 орчим их наяд төгрөг нь тэтгэвэр, Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгө. Уул нь энэ бол төрийн мөнгө биш. Тэгэхээр бид өөрөө өөрсдөө энэ нэг чагтан түгжээ хийгээд, тэгээд эндээс би юу харагдаад байна вэ гэхээр ер нь ирэх энэ 3 жил энэ иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд, тухайлбал тэр тэтгэвэр, цалин нэмэгдүүлэхэд яг ямар бодлого барих юм бэ гэдгийг би тодруулж асуумаар байна?

Саяын энэ баахан төсвийн тогтвортой байдал 24 хувь гэдэг ийм зүйлийг оруулж ирээд, эндээ барихгүй бол болохгүй байгаа юм гэдэг зүйлийг ингээд яриад суугаад байдаг. Гэтэл яг манайх өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүнээ яг бодитой тооцож чадаж байна уу? Далд эдийн засаг ихтэй, захын нэг том компани, аж ахуйн нэгж байгууллагуудын албан тушаалтны кармагаас нь хэдэн 10 тэрбумаараа гараад ирээд байдаг. Тэр их олон мөнгөнүүд нь энэ орон сууцны Улаанбаатар хотоор дүүрэн байгаа хоосон хүн амьдардаггүй. Түрүүн тэр Батнайрамдал гишүүний хэлдэг тэр юу чинь баахан орон сууц ингээд угаагаад байдаг юм байна гэж байна шүү дээ. Хүн амьдардаггүй, тэгээд тэрийгээ зараад, мөнгө угаагаад байдаг. Тэр нь яадаг вэ гэхээр жирийн нэг хөөрхий төрийн албан хаагч орон сууц авъя гэхээр тэрийг нь хөөрөгддөг. Тэгэхээр нэг иймэрхүү нэг ийм сүлжээнд орчихсон байгаад байна.

Төрийн банкны Удирдах зөвлөлийн дарга байж байх шиг байна. Тэлмүүн байх, одоо хэвээрээ байгаа болов уу гэж бодож байна. Ахмадын тэтгэврийн зээл гээд Төрийн банк нь өөрөө 100 хувь эзэмшдэг 19,3 болгоод нэмчхэж. Эрсдэл нь, буцаан төлөлт нь 97, 8 хувьтай. Гэтэл өнөөдөр жирийн ахмад иргэн 600 мянган төгрөгийн тэтгэвэртэй ахмад жилийн 19 хувийн хүүтэй тэтгэврийн зээл аваад байж байна шүү дээ. Гэтэл бид гадаадад Ирээдүйн өв сангийнхаа мөнгийг 4 хувиар хадгалаад сууж байдаг. Тэгэхээр энэ яг ний нуугүй харахад эрс тэс тийм юутай байна. Нэг ахмад өдөрт 20 мянган төгрөгөөр амьдарч байна л даа өдөрт шүү. Тийм учраас энэ ахмадууд чинь тэтгэврийн зээлийн ийм дарамтын циклд орчихсон байгаад байгаа юм.

Р.Сэддорж: 8 номер эхлээд хариулъя Сангийн яам. Статистик 8 номер.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. 2025 оны 9 дүгээр сарын байдлаар инфляц улсын хэмжээнд жилийн 9 хувьтай. Энэ дотроо бараа бүтээгдэхүүний бүлгээр үзвэл хүнсний инфляц жилийн 10,4 хувийн өсөлттэй, хүнсний бус 8,5, барааны инфляц 7, үйлчилгээний инфляцын түвшин 15 хувьтай гарсан байгаа. Статистикийн байгууллагаас инфляцын төсөөлөл хийдэггүй, зөвхөн гүйцэтгэл гаргадаг. Эдийн засгийн хөгжлийн яам төсөөлөл тал дээр хариулах болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Дараагийн асуулт 5 номер.

И.Батхүү: Эрдэнэбат гишүүний асуусан асуултаас холбогдох хариултуудыг хэлье. Инфляцын тооцооллыг 26 онд 7 хувь гэж тооцоолсон байгаа. 7 хувь тооцоолохдоо энэ төсвийн зарцуулах зардлын хэмжээ, нийт эдийн засагт явагдаж байгаа үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүдийн бүхий л нөлөөллийг холбогдох загвар тооцооллыг гаргаж тооцсон байгаа. Ер нь инфляцыг бууруулах чиглэлээр 2 талын арга хэмжээ авч явуулах ёстой. Нэг талаасаа Монголбанк эрэлтийн гаралттай инфляцыг бууруулах чиглэлээр мөнгөний бодлогоо хэрэгжүүлээд явах ёстой. Засгийн газрын зүгээс нийлүүлэлтийн гаралттай инфляцыг бууруулах чиглэлээр холбогдох хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн үр дүнг нь анхаарч ажиллах ёстой. Энэ 2 бол эцсийн үр дүнгээрээ бодлогын хувьд нийцэлтэй байгаа гэж харж байгаа. Монголбанкны хувьд 6 хувь дээр +, -2 хувь гэсэн интервалд инфляцын зорилгоо тавьж байгаа. Бидний тавьж байгаа 7 хувийн зорилт энэ зорилтод нийцэж байгаа.

Р.Сэддорж: 6 номер Төрийн банкны талаар хариулъя.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн, асуултад хариулъя. Төрийн банк хувьцаат компани нь хөрөнгийн биржид хувьцаагаа нээлттэй гаргасан хувьцаат компани. Тэгэхээр олон мянган хувьцаа эзэмшигчдээ ноогдол ашиг, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон компанийн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлээд явдаг. Банкны тухай хуулиар 31.4.5-д Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохыг хориглодог. Тэгэхээр яг банк бол банкны салбар дахь банкныхаа бизнесийг өдөр тутмын үйл ажиллагаанд эрхлээд явж байгаа. Аливаа зээлтэй холбоотойгоор бусад банкнуудаас илүү хөнгөлөлттэй нөхцөл олгоход улсын төсвийн татаас юм уу ийм давуу эрхтэй нөхцөл Төрийн банканд ямарваа хэлбэрээр байдаггүй. Зах зээл дээр байгаа хүүгийн түвшиндээ үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Р.Сэддорж: Монголбанк хэдэн номер вэ, байгаа юм уу? Монголбанк төсөв дээр ирэх албагүй. Тодруулах уу? Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Тэгэхээр бодит байдал ийм л байна л даа. Төсөв дээр 6 хувиар төсөөлөөд ороод ирчихсэн, хүнс нь 10 хувь болчихсон, үйлчилгээ 15 болчихсон, хүнсний бус 8,5. Тэгэхээр манай нийт иргэдийн маань, ялангуяа тэр ахмад, бага, дунд цалинтай хүмүүсийн чинь дийлэнх нь нийт орлогынх нь үндсэндээ бараг дийлэнх нь хүнсний хэрэглээ байдаг. Тэгэхээр энэ чинь өөрөө цаашдаа та бүгдийн буруу тооцоолол, эсхүл хэт өөдрөг төсөөллөөс болоод иргэд өөрөө бодит орлогоо алдах, тэгээд ирэх 3 жил бид нэг инфляцын дөнгөн данган хоцорсон нөхөөд л яваад байхаар 4 жилийн дараа гэхэд нэг бодит орлого нь хасах тэдэн хувьтай гэдэг байдал л үр дүн бид хүлээх байхгүй юу. Тийм учраас бол энийг хэлж байгаа юм. Тэр Төрийн банканд би бүх банкнуудаас хүү авсан, бараг хамгийн өндөр хувьтай хүү нь Төрийн

банк нь орж явж байна лээ. 18 явж байсан 19 болгосон гэж байгаа юм. Тийм учраас би энийг энэ банкнуудын хүүгийн асуудал дээр ер нь цаашдаа яах.../минут дуусав/

Р.Сэддорж: Эрдэнэбат гишүүн хариулт хангалтгүй гэж 1 минут.

С.Эрдэнэбат: Энэ зээлийн, ахмадын зээлийн юуг огцом оролцсоноос болоод ахмадууд ямар шаардлага тавиад байгаа вэ гэхээр бид зээлээс зээлийн хооронд амьдарч байсан, огцом ингээд зээлийн хүүг бууруулахаар дор хаяж бидний амьжиргаанд хүрэх тэтгэвэр өгөөч гээд энэ чинь төсөвт нөлөөлөх гээд байна л даа. Тэгэхээр би энэ Сангийн яам, Монголбанк эд нар бол ярьж байж шийдсэн болов уу гэж бодож байна. Анх Засгийн газраас тэтгэврийн зээлийн хэмжээг хязгаарла гэдэг ийм чиглэл өгсний дагуу Монголбанк шийдчихсэн. Одоо энэ чинь эргээд төсөвт нөлөөлж байгаа. Би тэгээд 10 хувь дээр нэмэх нь 100 мянган төгрөгөөр нэмчихье гэсэн чинь одоо пүү паа энэ бараг поп шийдвэр энэ тэр гэж. Инфляцыг нь ядаж хаагаад, дээр нь жилдээ нэг зуухан мянган төгрөг л нэмье гэж ийм саналыг аргаа ядаад оруулж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг Сангийн яам зохих хэмжээгээр нь дэмжиж өгөөрэй. 600 мянган төгрөгийн тэтгэвэртэй хүнийх 100 хэдэн мянган төгрөгөөр л нэмэгдэж байгаа асуудал шүү дээ.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Олон дарга нартай, тэгэхдээ аж үйлдвэргүй улс хөгждөггүй гэж хүмүүс яриад байдаг. Энэ танхимд их олон дарга харагдаж байна. Гэхдээ бид Байнгын хорооны даргаа, өнөөдрийн хурал нэг ийм оршуулга хийж байгаа юм шиг ийм гунигтай, ямар ч тэмүүлэлгүй, энэ нэг Монгол Улсыг хөгжүүлбье, 2026 онд нэг шинэ зүйл хийчихье гэдэг ийм бодол санаа байхгүй байгаа юм шиг харагдаж байна. Та бүхнийг буруутгаж байгаа юм биш, манай эрхлэх асуудал биш, өөр яамны асуудал, би мэдэхгүй байна, сайд байхгүй байна гээд хаана хаанаа ингээд хэдүүлээ нэг ажилдаа эзэн болмоор байна. Хууль тогтоох байгууллага нь хууль тогтоох байгууллага шиг, гүйцэтгэх байгууллага нь ингээд гүйцэтгэх байгууллага шиг ингээд ажилдаа эзэн болохгүй бол энэ улс орон чинь хөгжиж дэвших битгий хэл хөгжлөөс хоцроод байна.

Тэгээд би 2 санал хэлье гэж бодож байна. Асуултыг бол больё. Та бүхэн энэ төсвийг оруулж ирэхдээ бүтээмж нэмэгдүүлж байгаа энэ газраа төсвийг ахиухан тавьж, илүү их бүтээмжтэй байх энэ зарчмыг л бариасай гэж бодож байна. Тухайлбал яг одоо шаардлага байхгүй сум болгон руу зам, авто зам тавьж байхаар энэ Улаанбаатараас-Замын-Үүд хооронд хос замыг тавьж болдоггүй юм уу? Ингэвэл бараа, үйлчилгээний чинь үнэ тариф тодорхой хэмжээгээр буурна шүү дээ. Шууд ингээд Засгийн газар Хос зам гэдэг хөтөлбөрийг хэрэгжүүлээд заавал ингээд галт тэрэгний очер дараалалд бизнес эрхлэгчид ачаа бараагаа хүлээх биш, ингээд авто тээврийн тракыг явуулдаг ийм систем рүү Монгол Улс нэвтэрч болохгүй юм уу?

Цаашдаа Европ-Азийг холбосон тээврийн логистик хийх чиглэлээр ийм амбиц байхгүй юм уу? Сум руу, баг руу зам тавих нь чухал юм уу, 2 тивийг, 3 тивийг холбосон энэ холболтоосоо мөнгө босгодог байх нь чухал биш юм уу? Арай нэг өөрөөр хандаач гэж бодож байна. Тэгээд энэ Баялгийн сангийн асуудлыг нэг хэсэг нь авч үрэх гэж байгаа юм шиг, нэг хэсэг нь хадгалах гэж байгаа юм шиг яриад байх юм. Баялгийн сангийн өгөөжийг тухайн жил юунд зарцуулах вэ гэдгийг Баялгийн сангийн Удирдах зөвлөл Улсын Их Хурал бол ярилцдаг байх хэрэгтэй. Тэр Ирээдүйн өв сангийн үндсэн хөрөнгөд гар хүрч болохгүй. Өгөөж энэ жил хэд байгаа юм, өмнөх

жилийнхээс яаж давсан юм, энэ өгөөжөө яах вэ гэдгээ улс орон шийдээд л явдаг шүү дээ. Тэр өгөөж дээрээ л ярьдаг.

Энэ хөрөнгө, хөгжлийн сангаа амилуулъя л даа. Улсын төсвийн мөнгө хаана хаанаа хүрэхгүй байна гээд байдаг. Хөгжлийн сангаараа энэ том бүтээн байгуулалтаа явуулъя л даа. 4 хувийн өгөөжтэй Баялгийн сан тэгээд өндөр хүүтэй зээл авч байна шүү дээ. Эдийн засгийн тооцооллоо ч гэсэн харьцуулаад хийчихмээр байх юм.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Би чуулган дээр асууя. Одоо ингээд та бүхэн энэ Хос зам хөтөлбөрийг 1 дүгээрт хэрэгжүүл.

2 дугаарт энэ ЖДҮ-ийн банк ч юм уу байгуулаад энэ жижиг, дунд үйлдвэрлэлүүдээ нэмэгдүүлэх чиглэлээр зээлээс том давж сэтгэх хэрэгтэй. Бадамсүрэн гишүүн зөв хараад байх шиг байна. Энэ Хөрөнгө оруулалтын сан гэдгийг Монголдоо байгуулаад, Баялгийн сангийн чинь доор. Тэгээд ингээд хөрөнгө оруулдаг, start-up-уудад хөрөнгө оруулдаг, жижиг, дунд үйлдвэрлэл үнэхээр ирээдүйтэй бол хөрөнгө оруулдаг, тэгээд төр бол хамгийн гол нь экспортыг нь дэмжих, экспортын тэр татварыг нь тэглэх энэ чиглэл рүү явбал Монгол Улсын хөдөө аж ахуйн жижиг, дунд үйлдвэрлэгчид энэ Ази руу гарах гарцууд нь байна шүү дээ. Тэгэхээр бид ингээд бүх юмыг ингээд дусаах маягаар төсвийг олон жил оруулж ирлээ. Энд дусаагаад эхийг нь эцэж, тулыг нь тураахгүй гэдэг энэ төсвийн бодлого чинь Монгол Улсыг хөгжүүлэхгүй байна.

Р.Сэддорж: Баатархүү гишүүн үг хэллээ. Гишүүд үг хэлж, асуулт асууж, хариулт авч байна. Би гишүүд бол зарлага талаас нь ярьж байгаа. Тэгээд зарлага нь орлоготойгоо ингээд тулчхаад энэ олон яамнуудын та бүхэн бол яах ч аргаа олохгүй ингээд байж байгаа. Орлогоо нэмэгдүүлэх ямар боломж байгаа вэ? Энэ дээр Сангийн яам хариулах уу? Эдийн засгийн хөгжлийн яам та хоёр маань товчхон хариулаадхаач. Ямар өөдрөг төсөөлөл байна, ямар боломж байна вэ? Энэ дээр хариулж өгөөч. Эдийн засгийн хөгжлийн яам 5 номер.

И.Батхүү: 2026 оны тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг тооцохдоо бид хамгийн бодитой байдлаар тооцоолохыг хичээсэн. Гадаад болон дотоод орчны тодорхойгүй байдал, гол экспортын бүтээгдэхүүн үнийн чиг хандлагыг олон улсын хөрөнгө оруулалт, судалгааны байгууллагуудын үнийн төсөөлөл, дотоодын хийсэн төсөөлөлтэй нийцүүлж авч үзээд, хилийн үнийг дундаж үнийг 70 ам.доллараар тооцсон. Үүнээс илүү өндөр үнээр тооцвол ер нь экспортын орлого хүрэхгүй. Ер нь үүн дээр суурилсан төсвийн орлогын хэмжээ хийсвэр төсөөлөгдөх эрсдэлтэй гэж үзэж байгаа. Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлэх боломжтой, удирдах боломжтой эрсдэл бол экспортыг хэмжээ байгаа. Экспортын хэмжээн дээр нүүрсний гаргаж болох экспортын дүнг бүх боомт, экспортлох боломжтой төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн дотоодын тооцоолол, бизнес төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөө, экспортын гэрээнд үндэслээд, хамгийн боломжтой бодитой хэмжээ 90 сая тонн гэж одоогийн байдлаар тооцоолсон.

Мэдээж төсвийн гүйцэтгэлийн явцад илүү их хэмжээгээр орлого орвол сайн. Төсвийн гүйцэтгэл бол төлөвлөлтөөсөө орлогын хэмжээ давж гарвал сайн байгаа. Үүнтэй зэрэгцээд зэсийн орлогын хэмжээ зэсийн олон улсын үнийн чиг хандлагыг дагаад нэмэгдэж байгаа. Өнгөрсөн жилүүдэд экспортын орлогын 2/3 нь нүүрсний

экспортын орлого байсан бол сүүлийн үеийн байдлаар зэсийн экспортын орлогын хэмжээ тэнцүү хэмжээнд хүртэл өссөн байгаа. Цаашдаа энэ орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр салбар болгон, яам болгон бас хичээж ажиллах, үүн дээр ялангуяа экспортын холболтын хил холболтын төслүүдээ амжилттай явуулах хууль, эрх зүйн орчин, холбогдох тогтоомж, зохицуулалтуудыг хялбарчлах чиглэлээр үргэлжлүүлж ажиллана гэж ойлгож байгаа.

Р.Сэддорж: Сангийн яам 8 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Товчхондоо ер нь бүх асуудлыг улсын төсвөөр шийднэ гэж угаасаа байхгүй. Энэ нь хэмжээ хязгаартай учраас. Нөгөө талдаа бид хэзээ өөр түвшинд очих вэ гэхлээр дотоодын нийт бүтээгдэхүүнээ л бид тэлж байж энэ асуудлуудыг зах зухаас нь бид шийдэх боломжтой болно. Ирэх жилийн төсөв ерөөсөө яг энэ чиглэл рүү л явж байгаа. Бид зарлагаа аль болох бага хэмжээнд барья гэж зорьж байна. Ингэснээрээ нөгөө талдаа мөнгөний бодлого талдаа орон зай гаргаж ирээд, зээлийн хүү багатай зээлийн олдоц, хүү багатай зээлийн олдцыг хувийн хэвшилд аль болох түлхүү гаргаж ирье. Төр нь бүх зүйлээ өөрөө хийгээд байдаг шиг гэдэг ийм агуулга явж байна.

Төсвийн тухай хуулиа дагуулаад бид Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиа хамтад нь өргөн барьчихсан байгаа. Нөгөө талдаа бид энэ зөвшөөрлүүдийг цахимжуулах асуудлыг цэгцлээд үндсэндээ дуусаж байна. Ингээд хувийн хэвшилдээ л бид аль болох боломжийг өгье, хувийн хэвшил дээрээ тулгуурлаж улсаа хөгжүүлье, тэлье гэдэг ийм л бодлого явж байгаа. Тийм.

Р.Сэддорж: Ер нь орлогоо их доогуур төлөвлөөд, тэгээд нөгөө цаг хугацааны дунд үед орлого их олоод, юу орлого төсөөлснөөс илүү олоод, тэгэнгүүт орлого их оллоо гэж сайшаагдах ийм юмнууд сүүлийн жилүүдэд ажиглагддаг. Одоо бол гишүүдэд яалт ч үгүй гишүүдийн хүсэлт, тойргийн асуудлууд энэ юманд ингээд орлогодоо тулчхаад байгаа учраас та бүхэн маань орон зай гаргаж өгөхдөө тун тааруу, тэгээд ингээд хугацааны явцад орлого төсөөлснөөс илүү олоод ирдэг ийм үзэгдлүүд байгаад байгаа юм байна. Тэгэхээр төлөвлөлт дээрээ илүү сайн анхаарах ёстой юм байна гэдгийг энд байгаа хүмүүст хэлье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулъя. Гишүүн гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж, үг хэлж болно. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Санал хураалт. 1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900239 төслийн кодтой “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд аймгийн Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 9 тэрбум 438 сая 300 мянган төгрөг, 2026 онд санхүүжих дүн 2 тэрбум 831,5 төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн, Бямбасүрэн, Лодойсамбуу. Бямбасүрэн гишүүн саналаа тайлбарлая.

Ш.Бямбасүрэн: Энэ боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэвэр нэмэгдүүлэх зэрэг асуудал нь нийгмийн шаардлага болоод байгаа. Тэгээд энэ асуудал цаашид аргалаад аргацаагаад өнгөрөх ямар ч тийм боломжгүй ийм байгаа гэдгийг бид хаана хаанаа

ойлгох хэрэгтэй. Тэгээд энэ удаагийн төсвийн төсөл дээр 22 зарчмын зөрүүтэй саналыг 3 гишүүн гаргаж байгаа. Нийт 1,2 их наядын эх үүсвэрийг гаргаж гаргаж болно гэсэн байдлаар гаргасан.

Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хороон дээр эдгээр 22 зарчмын зөрүүтэй саналаас 3 нь бас Байнгын хороонд харьяалагдаж байгаа. Эхнийх нь энэ Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж гээд. Энэ төсөл нь өөрөө судлаад үзэхээр 20 онд анх, 2020 онд анх Засгийн газрын хөтөлбөрт ороод, 22 оноос эхлээд санхүүжигдээд эхэлсэн. Анх 26 онд дуусна гэж байсан төсөл маань өнөөдөр ингээд дахиад үргэлжлээд сунгагдаад л яваад байгаа юм. Тэгээд нэг ийм зальт байдлаар ингээд ийм юм юмнуудаа хийдгээ болих хэрэгтэй. Өмнөх юмнуудыг нь бид үр дүнг нь хэмжих хэрэгтэй, 26 он дуусна гэж байснаа ахиад 26 онд шинэ төсөл, хөтөлбөр болгоод дараагийн шатных нь гээд ахиад бүүр 28 он хүртэл явуулахаар болчихсон. Энэ чинь үндсэндээ бүхэл бүтэн 2 сонгуулийн цикл одоо үргэлжилж байгаа төсөл болчихож байгаа юм. Ашиглалтад орсон юм байхгүй. Нөгөө яриад байгаа баахан ажлын байр нэмэгдүүлнэ гэсэн юм байхгүй.

Тэгээд энэ ашиглагч байгууллага нь аягүй тодорхойгүй болох гэж байгаа юм. Өмчлөгч байгууллага нь аягүй тодорхойгүй байгаа юм. Өнөөдөр орон нутгийн өмчит Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорац гэдэг орон нутгийн өмчит оролцоотой үйлдвэрийн газар байгуулчихсан байгаа юм. Энэнийх нь хувьцаа эзэмшигчдийнх нь мэдээллийг нь ороод харахаар 14 хуулийн этгээд байгаа юм. Тэгээд бид улсын төсвөөс санхүүжүүлж байгаа юмаа яг гоё сайхныг нь яриад байдаг, яг нарийн цаана нь болж байгаа процессыг нь бид мэдэхгүй байна. Гишүүд маань энийг анхаараач. Ер нь эцсийн өмчлөгч нь хэн байх юм, төсөл хэрэгжүүлэхэд нь хуулийн этгээдүүд ямар үүрэг оролцоотой байх юм гэдэг юмыг тодруулаад, нягталж харах олон асуудал байна гэж үзэж байгаа учраас шинээр эхэлж байгаа энэ 2 асуудлыг хасаж, эх үүсвэр гаргах шаардлагатай гэж үзэж байгаа юм. Тэгээд энэ хасаж байгаа санал нь өөр ямар нэгэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго байхгүй. Зүгээр л хэмнэлт хийх зорилготойгоор энэ саналыг оруулж байгаа учраас гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Баярлалаа. Шинээр хийгдэж байгаа төсөл юм байна тийм ээ? Ингээд 1 дэх санал хураалт. Саяын уншсан энэ 3 гишүүний гаргасан саналыг хасах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Гишүүд 33,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Санал хураалт. 2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900237 төслийн кодтой Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, аймгийн Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3 тэрбум 953,6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 1 тэрбум 779,2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн, Бямбасүрэн, Лодойсамбуу. Тайлбарлах уу? Бямбасүрэн гишүүн саналаа тайлбарлая.

Ш.Бямбасүрэн: Гоё сайхан юм яриад 8 жил үргэлжлэх нэг ийм төсөл яриад байгаа юм. Одоо тэгэхдээ бид энийг ер нь хувийн хэвшилээрээ хийлгэх болоогүй юм уу гишүүдээ? Хэзээ бид хувийн хэвшилдээ итгэж, энэ ажлуудаа явуулдаг болох юм бэ? Өнөөдөр бидэнд хууль нь байгаа шүү дээ. Аж үйлдвэр, технологийн паркийг хувийн хөрөнгөөр хийвэл НӨАТ-аас нь тэдэн жил чөлөөлнө гээд хувийн хэвшилтийнхэнд зориулсан хууль нь байж байгаа юм. Гэтэл бид энийгээ дэмжихийн

оронд улсын төсвийн хөрөнгөөр хийж байгаа юм. Одоо тэгээд улс баахан бас нэг ийм төрийн өмчит компаниудтай болох гээд байгаа байхгүй юу. Өнөөдөр бидэнд хангалттай олон асуудалтай төрийн өмчит компаниуд байгаа. Энийгээ бид нэмж яах гээд байгаа юм бэ?

Энэ өмнөх жилүүдэд орсон гүйцэтгэлийг бид ахиад хянах шаардлагатай, 50 гаруй тэрбум төгрөгөөр бид дэд бүтцийн ажлуудыг нь хийчихсэн. Ахиад бид цахилгааных нь юмыг нь хийнэ гээд. Энэ өмнө жилүүдэд суучихсан байгаа, ахиад ингээд л нэмж юмнууд гаргаж ирээд байгаа юм. Одоо энийгээ ер нь болихгүй юм уу? Тэгээд гишүүдийг яаж хэлэх юм та нар маань энийг дэмжиж өгөөч. Бидэнд үнэхээр тулгамдсан маш олон асуудлууд байгаа юм. Энэ 28 онд дуусахгүй, одоо харж байгаарай дараагийн заль нь ахиад ороод ирнэ. Энэнтэй холбоотой зам нь орж ирнэ, бусад явган хүний зам нь гээд бөөн юмнууд нь ахиад нэмж орж ирнэ. Одоо больё л доо хэдүүлээ. Цогцоор нь харж байгаад энийгээ шийддэг больё л доо.

Р.Сэддорж: Дээрх 3 гишүүний гаргасан хасахыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. 27,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, аймгийн Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8 тэрбум 396,8 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 3 тэрбум 778,6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн, Бямбасүрэн, Лодойсамбуу. Бямбасүрэн гишүүн тайлбарлая санал.

Ш.Бямбасүрэн: Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга гэнэ. Энэ аялал жуулчлал гэдгийг нь оруулаад яах гэж байгаа юм гэхээр өвлийн аялал жуулчлалд зориулна гэж байгаа. Барилга бариад аялал жуулчлал хөгждөг бол мэдэхгүй та нар юу гэж хараад байгаа юм. Аялал жуулчлалыг ер нь ойлгож байгаа юм уу гэдгийг би буцаагаад асуумаар байгаа байхгүй юу. Өвлийн аялал жуулчлалд зориулаад барилга барина гэдэг үнэхээр ойлгомжгүй юм байгаа юм.

Аялал жуулчлал гэдэг чинь өөрсдөө тусдаа бүтээгдэхүүн байдаг юм шүү дээ. Бүтээгдэхүүнийг тойрсон тэр экосистемийг хэлдэг болохоос биш төрийн байгууллагын барилгыг хэлдэггүй юм. Хувийн хэвшил дээр суурилж, энэ аялал жуулчлал хөгждөг болохоос биш улс аймагт ийм барилга бариад хөгждөггүй юм. Баян-Өлгий аймгийн төв дээр спортын барилга бол байгаа шүү дээ. Тэрийгээ томруулдаг юм уу, засдаг юм уу, сайжруулдаг юм уу ийм төсөв оруулаад ирвэл дэмжиж болж байна. Тэгэнгүүт ийм аялал жуулчлал нэрээр ингээд төсөв дээр ингээд ийм өндөр дүнтэйгээр барилга барихыг би буруу гэж үзэж байгаа юм. Тийм учраас гишүүдийг ийм юман дээр хэдүүлээ өөрсдийгөө хуурахаа больцгооё. Энийг хасах саналыг маань дэмжиж өгөөч гэж хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Ирцээ бүрдүүлье. Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн, Бямбасүрэн, Лодойсамбуу нарын гаргасан Аялал жуулчлал, соёл, спортын цогцолборыг барих төслийг хасах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202 тэрбум 137,9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23

тэрбум 950,1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 641,6 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Шихихутаг нууц товчоо түүхэн аялал жуулчлалын цогцолбор барилга”-ын нэмэлт төсөв /Хэнтий аймаг, Норовлин сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 ондоо, төсөвт өртөг, санхүүжих дүн 641,6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Идэрбат. Идэрбат гишүүн байна уу? Байхгүй байна. Ингээд энэ саналаар нэмэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 44,4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэл хатуу хучилттай авто зам, 152,5 км /Хэнтий Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202 тэрбум 137,9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 24 тэрбум 950,1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 238,6 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Их хуралдай цогцолборын барилгын гадна тохижилтын нэмэлт ажил, хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 238,6 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Идэрбат. Энэ саналыг нэмэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 50 хувийн саналаар яг санал дэмжигдсэнгүй. Идэрбат гишүүн өөрөө байхгүй байна.

7, 6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5 км, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202 тэрбум 137,9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23 тэрбум 950,1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 685 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Монголын нууц товчоо цогцолборын барилга”-ын гадна тохижилтын нэмэлт ажил, /Хэнтий аймаг, Дэлгэрхаан сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 685 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Идэрбат. Ингээд дэмжихийг, нэмэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 50 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Яг тэнцлээ.

7.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700119 төслийн кодтой, “Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюун ухаан, их өгөгдлийн суурь дэд бүтцийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 19 тэрбум 445 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын төсвийн багцад “Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын ТЭЗҮ, зураг төсөв,” хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Золжаргал гишүүн байна уу? Ингээд нэмж тусгахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 44,4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

8.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40 тэрбум төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад “Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүүтерийн гүүрэн тусгай зам барих ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан

Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Золжаргал гишүүн байхгүй тийм ээ? Ингээд нэмэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны гаргах, хорооноос гаргах санал, дүгнэлтийг, Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа уншиж, Төсвийн байнгын хороонд уншиж танилцуулна.

15.34 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА